

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ын 2025 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг  
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088 Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [Buynundrakhb@audit.gov.mn](mailto:Buynundrakhb@audit.gov.mn)

Аудитор: А.Лхагвагэрэл  
Утас: 70359826 Цахим хаяг: [lkhagvagerela@audit.gov.mn](mailto:lkhagvagerela@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### **ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,  
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: (976) 7035 9826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.15 № 93  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ГЭР БҮЛИЙН  
ОРДНЫ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ЗОЛЗАЯА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн гэр бүлийн ордны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн гэр бүлийн ордны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 32,186.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Тайлант оны эцэст 500.0 мянган төгрөгийн урамшууллыг илүү тооцож олгосон;
- Байгууллагын даргад 1,558.1 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг цалинтай давхардуулан олгосон;
- Авлагын дансанд бүртгэлтэй хувь хүнээс авах 30,128.5 мянган төгрөгийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.1.10-т "эрх хэмжээний асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах", Компанийн тухай хуулийн 84.4-т Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.3-т "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1-д "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-д "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-т "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талуудын тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж заасныг зөрчсөн байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд орлогыг 122,876.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 85,018.4 мянган төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 81,208.9 мянган төгрөгийн хөрөнгөтэй, 74,992.3 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаа нь төлбөрийн чадварын харьцаа алдагдаж, өөрийн хөрөнгөөр өр төлбөрөө барагдуулах боломжгүй байгааг илтгэж байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд түрээсийн төлбөр болон дархан бэр, уран бэрийн үйлчилгээний хураамжийг тус бүр 20 хувиар нэмж өөрийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажилласан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

**ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,272,563.48	58,797,305.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,370.82	132,188.59
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	4,096.82	783.42
31110	Төгрөг	4,096.82	783.42
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	44,274.00	131,405.17
31210	Төгрөг	44,274.00	131,405.17
31213	Арилжааны банк дахь харилцах	44,274.00	131,405.17
33	АВЛАГА	1,757,629.76	30,643,194.97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	270,000.00	-
33500	Бусад авлага	1,487,629.76	30,643,194.97
33510	Байгууллагаас авах авлага	1,487,629.76	30,643,194.97
35	БАРАА МАТЕРИАЛ	23,466,562.90	28,021,921.98
35400	Хангамжийн материал	23,466,562.90	28,021,921.98
35470	Бусад хангамжийн материал	23,466,562.90	28,021,921.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,903,344.33	22,411,589.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,903,344.33	22,411,589.13
39200	Биет хөрөнгө	5,903,344.33	22,411,589.13
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,709,885.48	34,858,085.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,915,066.01)	(16,267,408.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,870,414.83	46,121,259.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,761,889.97)	(42,300,347.37)
39301	Программ хангамж	2,132,454.55	2,132,454.55
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,132,454.55)	(2,132,454.55)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>31,175,907.81</b>	<b>81,208,894.67</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	97,055,613.89	74,992,257.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	97,055,613.89	74,992,257.29
41300	Өглөг	97,055,613.89	74,992,257.29
41360	Бусад өглөг	97,055,613.89	74,992,257.29
41361	Байгууллагад төлөх өглөг	9,774,610.86	5,073,570.04
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,111,983.84	3,710,407.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	42,223,106.05	59,881,764.39
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	40,945,913.14	6,326,515.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(65,879,706.08)	6,216,637.38
51	Засгийн газрын хувь оролцоо	(65,879,706.08)	6,216,637.38
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	43,554,506.00	43,554,506.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	4,512,531.80	27,244,531.80
51200	Хуримтлагдсан үр дүн	(117,586,443.88)	(68,222,100.42)
51210	Өмнөх үеийн үр дүн	(78,474,408.13)	(145,739,078.35)
51220	Тайлант үеийн үр дүн	(39,112,035.75)	77,516,977.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,639,700.00	3,639,700.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>31,175,907.81</b>	<b>81,208,894.67</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	91,846,193.07	85,019,385.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,846,193.07	85,019,385.04
120	Нийтлэг татварын бус орлого	91,846,193.07	85,019,385.04
120009	Бусад орлого	-	1,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	91,846,193.07	85,018,385.04
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	130,958,228.82	190,564,061.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,958,228.82	190,564,061.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	130,958,228.82	190,564,061.16
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,699,276.39
210408	Бараа материал акталсны зардал	-	2,699,276.39
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129,477,895.95	187,864,784.77
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	129,477,895.95	187,864,784.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,480,332.87	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,480,332.87	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(39,112,035.75)	(105,544,676.12)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	183,061,654.05
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	183,061,654.05
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	183,061,654.05
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(39,112,035.75)	77,516,977.93

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	108,597,278.00	242,257,644.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	108,597,278.00	242,257,644.05
120	Нийтлэг татварын бус орлого	108,597,278.00	242,257,644.05
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	108,597,278.00	242,257,644.05
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,033,342.84	242,173,826.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,033,342.84	242,173,826.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,033,342.84	242,173,826.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,663,812.34	106,754,902.21
210106	Ажилчдад төлсөн /ТӨҮГ/	58,663,812.34	106,754,902.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	78,167,644.18
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	-	78,167,644.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,771,310.00	21,229,782.26
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	22,771,310.00	21,229,782.26
2104	Хангамж, бараа материалын зардал	17,419,248.50	27,196,230.00
210402	Тээвэр, шатахуун	-	780,000.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	17,419,248.50	26,416,230.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,178,972.00	8,825,267.63
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,854,672.00	166,263.63
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	7,324,300.00	8,659,004.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	563,935.16	83,817.77
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	584,585.50	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	584,585.50	-
2200	Дотоод эх үүсвэрээр	584,585.50	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	584,585.50	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(584,585.50)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	<b>(20,650.34)</b>	<b>83,817.77</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>69,021.16</b>	<b>48,370.82</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>48,370.82</b>	<b>132,188.59</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(78,290,862.73)	(26,584,124.93)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(183,545.40)	(183,545.40)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(78,474,408.13)	(26,767,670.33)
Тайлант үеийн үр дүн	-	-	(39,112,035.75)	(39,112,035.75)
2024 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(117,586,443.88)	(65,879,706.08)
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(117,586,443.88)	(65,879,706.08)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	22,732,000.00	-	(28,152,634.47)	(5,420,634.47)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	70,799,037.80	3,639,700.00	(145,739,078.35)	(71,300,340.55)
Тайлант үеийн үр дүн	-	-	77,516,977.93	77,516,977.93
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,799,037.80	3,639,700.00	(68,222,100.42)	6,216,637.38

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Борлуулалтын орлого	122,876,000.00	85,019,385.04
Нийт зардал	122,816,000.00	190,564,061.16
Татвар ногдох орлого	60,000.00	(105,544,676.12)
Татвар	6,000.00	
Цэвэр ашиг	54,000.00	(105,544,676.12)
Шаардлагатай хөрөнгө оруулалт		
Хуримтлагдсан ашиг	54,000.00	(105,544,676.12)

## **ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар залруулсан алдаа байхгүй.

Аудитаар нийт 32,186.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 31,686.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### **3.1 Төлбөрийн акт**

Тайлант оны эцэст 500.0 мянган төгрөгийн урамшууллыг илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

Байгууллагын даргад 1,558.1 мянган төгрөгийг ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон, тайлант онд үүссэн хувь хүнээс авах 30,128.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шилэн дансны цахим нэгдсэн системд мэдээлэл байршуулахтай холбоотой зөрчлүүдэд 3 албан шаардлага хүргүүлээ.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

#### **Илрүүлэлт:**

Тайлант онд шинээр гэрээ байгуулсан түрээслэгчдийг сонгон шалгаруулалтгүйгээр түрээсийн гэрээ байгуулан ажилласан байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Шинээр түрээсийн гэрээ байгуулахдаа Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмын дагуу сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгарсан түрээслэгчтэй гэрээ байгуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
500.0 мянган төгрөгийн урамшууллыг илүү тооцож олгосон	1	500.0	1	500.0								
Байгууллагын даргад 1,558.1 мянган төгрөгийг ээлжийн амралтын цалинтай давхардуулан олгосон	1	1,558.1			1	1,558.1						
тайлант онд үүссэн хувь хүнээс авах 30,128.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	30,128.5			1	30,128.5						
Түрээсийн гэрээг шинээр байгуулахдаа Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмын дагуу сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгарсан түрээслэгчтэй гэрээ байгуулан ажиллах.	1	0					1	-				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>32,186.6</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>2</b>	<b>31,686.6</b>	<b>1</b>	<b>-</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд нийт 5 талбарт хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		